



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.15 № 3/185
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чойжин ламын сум музейн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Чойжин ламын сум музейн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт(УСНББОУС)-ын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Чойжин ламын сум музейн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА



ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙ ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAГ-ын САГ-ын дарга
Тэргүүлэх аудитор: С.Энхзаяа
Утас: 261663
Аудит менежер: Н.Золзаяа
Ахлах Аудитор: Н.Батсайхан
Утас: 260512

Хаяг: Засгийн газрын IV байр
Улаанбаатар-46, Бага тойруу 6
Вэб хуудас: www.audit.mn

Эйч Эл Би Монголиа АУдит ХХК,
Захирал: Ч.Энхтуяа,
Утас: 99110581

Аудит менежер: М.Нурболат
Утас: 99027275
Аудитор: И.Юмчиндулам
Утас: 99094533
Туслах аудитор: Ц.Солонго

Хаяг: Сүхбаатар дүүрэг 1 дүгээр хороо
“Гурван гал” төв 5 давхар, 510
тоот
Утас: 326275
Цахим хаяг: www.HLBM.mn
И-мэйл: info@hlbm.mn

Аудитынтайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны тухай мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Чойжин ламын сүм музейн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийх хуваарь 2016 оны 9 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын Ерөнхий аудиторовын А/93 дугаар тушаалаар батлагдсаны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд (САГ/201/323/СТА) аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Музейн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Бэлтгэсэн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 1 дүгээр сарын 27-ноос 2-р сарын 06-ны өдөр хүртэл хийхээр төлөвлөн “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн аудитор И.Юмчиндулам хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Чойжин ламын сүм музейн 2016 оны III улирлын санхүүгийн тайланд 2016 оны 12 дугаар сарын 10-наас 26-ны хооронд аудит хийж, гүйцэтгэсэн ажлын баримтуудыг жилийн эцсийн аудитын дүгнэлтэд нэгтгэн тооцохоор төлөвлөсөн.

Чойжин ламын сүм музей 2016 оны санхүүгийн тайлангаа 2016 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 14 тоот албан бичгээр, 1-р сарын 30-ны өдөр файлаар ирүүлсэн.

“Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК аудитыг 2016 оны 1-р дүгээр сарын 27-ноос 2-р сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2-р сарын 25-нд Чойжин ламын сүм музейн удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Музейн захирлын 2016 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 01 тоот тушаалаар “Музейн дотоод журам”, “Эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэх журам”, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг тус тус шинэчлэн баталсан байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Чойжин ламын сүм музей нь шашны соёл урлагийн хосгүй өв, соёлыг хойч үедээ өвлүүлэн үлдээх, тэднийг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, судлан шинжлэх, сурталчлан таниулах зорилгоор ажилладаг ба 2016 оны байдлаар нийт 993 дэсийн 6376 ширхэг үзмэртэй байна.

1940 онд Шинжлэх ухааны хүрээлэнд шилжүүлэн өгч, БНМАУ-ын бага хурлын тэргүүлэгчдийн 1941 оны 11-р сарын 13-ны өдрийн хуулийг үндэслэн уг сүмийг улсын 1 дүгээр хамгаалалтад авчээ. Уг сүмийн доторх тавилгын зүйлүүд нь урлаг, уран сайхны хувьд иж бүрэн шашны урлагийн бэлэн үзмэр болох учир 1942 онд шашны музей болгосон байна.

Монгол Улсын Гэгээрлийн сайдын 2000 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 293/7 тоот тушаалаар Чойжин ламын сүм музей нь шашны түүхийн музейн харъяалалаас гарч бие даасан байгууллага болсон.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн горим, сорилуудыг гүйцэтгэн ТАБ-СТА-В-3 маягтад баримтжуулав.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн дотоодын бодлогын баримт бичиг байхгүй. Харин ССАЖС-ын 2013.12.30-ний А/465-тоот тушаалаар тус яамны харьяа байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг баталсан.

Чойжин ламын сүм музейн 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 135 тоот албан бичгээр “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”, “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам”-ыг тус тус шинэчлэх саналыг БСШУСЯ-ны санхүү эдийн засгийн газарт хүргүүлсэн байна.

Музей нь нягтлан бодох бүртгэлдээ Сангийн яамны зөвшөөрөлтэй Санхүүгийн тооцоолох ХХК-ийн Acolous 3.0 төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн програмашигладаг ба цогц мэдээллийн систем ашигладаггүй тул мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй юм./ТАБ-СТА-В-2/

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан Сангийн Сайдын 2006 оны 388-р тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэсэн байна.

5. Материаллаг байдал

Үйл ажиллагаа нь цомхон, 1 төрлийн үйлчилгээ үзүүлдэг, нийт 20 ажилтантай төсвийн байгууллага тул төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нийт орлого, зардлыг суурь болгон 2 хувиар буюу 4,845.2 мянган төгрөгөөр тооцсон. Гүйцэтгэлийн явцад материаллаг байдлыг дахин үнэлээд төлөвлөлтийн шатанд тооцсон материаллагын түвшинг хэвээр үлдээлээ. /ТАБ-СТА-В-1/

6. Дотоод хяналт:

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтын үйл ажиллагаа

нь материаллаг алдаа гарахаас хамгаалах, жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтыг тодруулах, судлах зорилготой юм. Чойжин ламын сүм музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад сайн байна.

Музейн захирлын 2016 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 04 тоот тушаалаар Дотоод хяналт шалгалтын ажилтан томилж, дотоод хяналт шалгалт зохион байгуулах ажлын удирдамж, шалгах хяналтын хуудас баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллажээ.

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 174,330.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 66,474.0 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 759.4 мянган төгрөг, нийт 241,563.6 төгрөгийн орлого олжээ. 2016 оны батлагдсан төсөв 242,983.9 мянган төгрөгөөс урсгал зардалд 241,563.7 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 1,420.2 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар хэмнэсэн байна.

8. Шилэн дансны тухай мэдээлэл

Музей нь Шилэн дансны тухай хууль, ЗГ-ын 2014.12.15-ны өдрийн 384 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахин хуудсанд музейн талаарх холбогдох мэдээллийг оруулж, музейн www.templemuseum.mn цахим хуудсанд шилэн дансны бие даасан цэс нэмж ашиглаж байна. Тайлант хугацаанд 5 саяаас дээш төгрөгийн зардлын гүйлгээ 1 удаахийсэн. 2016 оны 4, 12 дугаар саруудад УАГ-аас шилэн дансны хэрэгжилтийг шалгаж зөвлөгөө өгсөн байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалттай байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 91 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 54 горим, сорил гүйцэтгэв. Сорилын үр дүнд ноцтой эсвэл материаллаг хэмжээний алдаа зөрчил илрээгүй.

10. Гол, онцлог гүйлгээний талаар:

Музейн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний үнийн дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа./ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт зардлын 50 хувийг эзэлж байна.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Байгууллагын бүтэц, орон тоо баталсан тушаал шийдвэр байхгүй, БСШУСЯ-наас хуулбарыг авахаар хүсэлт тавьсан ч олдохгүй байна гэсэн хариу өгсөн байна. Одоогийн байгаа бүтэц, орон тоогоор олон жил ажилласан байна.

Шийдвэрлэсэн байдал:Холбогдох дээд шатны байгууллагаар бүтэц, орон тоогоо шинээр батлуулж мөрдөх талаар аудитын зөвлөмж хүргүүлэв.

- Харилцахын зарлагын гүйлгээгээр 3 хүнд ажил гүйцэтгэх гэрээгээр олгосон 3.5 сая төгрөгөөс суутган тооцох НДШ 10 % 350.0 мянган төгрөг, ажил олгогчийн төлөх НДШ 11% 385.0 мянган төгрөг, нийт 735.0 мянган төгрөгийг дутуу тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус,шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343,359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн” гэсэн заалтыг зөрчсөнбайна.

Шийдвэрлэсэн байдал:Менежментийн захидлаар НДШ-ийг нөхөн тооцож, санхүүгийн тайланд үнэн зөв тусгахталаар зөвлөмж хүргүүлэв.

- Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн хөрөнгийн хэмжээ 1,029.1 сая төгрөгөөр бүртгэгдсэн боловч, Санхүүгийн тайлангаар Засгийн газрын оруулсан хөрөнгө 1,258.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба 229.7 сая төгрөгөөр зөрж байна.

Шийдвэрлэсэн байдал:Менежментийн захидлаар зөвлөмж хүргүүлэв.

- НДШ-ийн тайлангаар 3,2 мянган төгрөгийн илүү төлөлтийг бүртгэлд тусгаагүй байгаа нь Сангийн Сайдын 2006 оны 388-р тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг (3.2 ба 3.3)зөрчиж байна.

Шийдвэрлэсэн байдал:Менежментийн захидлаар зөвлөмж хүргүүлэв.

12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг алдаа тогтоогдоогүй болно. Материаллаг бус 735.0 мянган төгрөгийн алдааг залруулах шаардлагагүй гэж үзсэн.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Музейн нийт хөрөнгийн 95.7 хувийг үзмэрүүд эзлэж байна. Аудитын зүгээс музейн үзмэрүүдийг тоолох боломжгүй байна. Засгийн газрын 1994 оны 233 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Түүх, соёлын дурсгалт зүйлийн тооллого явуулах журам”-ын дагуу музейн үзмэрүүдэд улсын тооллого 4-н жилд 1 удаа хийдэг ба уг тооллого 2017 онд тохионо.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Чойжин ламын сум музейн 2016оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 735.0мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнд зөвлөмж хүргүүлэв.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Чойжин ламын сум музейн 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 2-ыг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг Дахин үнэлгээний нөөц дансны 3,000.0 мянган төгрөгийн үлдэгдэл нь дахин үнэлгээ хийгдсэн хөрөнгө данснаас хасагдаагүй байгаа тул хэрэгжүүлэх шаардлагагүй гэсэн тайлбар өгсөн.

17. Зөрчилгүй санал дүгнэлт

Чойжин ламын сум музейн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 5 хуудас, хавсралтууд 14 хуудас, тус тус хавсаргав.



ЧОЙЖИН ЛАМЫН СУМ МУЗЕЙ ТӨСВИЙН
БАЙГУУЛЛАГЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

YAG-ын САГ-ын дарга
Тэргүүлэх аудитор: С.Энхзаяа
Утас: 261663
Аудит менежер: Н.Золзаяа
Утас: 260512
Ахлах Аудитор: Н.Батсайхан
Утас: 260512

Хаяг: Засгийн газрын IV байр
Улаанбаатар-46, Бага
тойруу 6
Вэб хуудас: www.audit.mn

Эйч Эл Би Монголиа Аудит ХХК,
Захирал: Ч.Энхтуяа,
Утас: 99110581

Аудитор: Г.Содбаяр
Утас: 99026270

Хаяг: Сүхбаатар дүүрэг 1 дүгээр
хороо
“Гурван гал” төв 5 давхар, 510
тоот
Утас: 326275
Цахим хаяг: www.HLBM.mn
И-мэйл: info@hlbm.mn

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Нийгмийн даатгалын тооцоо.....2

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1
Улсын бүртгэлийн гэрчилгээний өөрчлөлт...3

Асуудал 2
Авлаг, өглөгийн талаар3

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Чойжин ламын сүм музейн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжөгсөн.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Төсвийн захирагчийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Нийгмийн даатгалын тооцоо**Тэргүүлэх ач
холбогдол №1**

Бодит байдал	Зөвлөмж
Харилцах дансны зарлагын гүйлгээгээр 3 хүнд ажил гүйцэтгэх гэрээгээр олгосон 3.5 сая төгрөгөөс суутган тооцох НДШ 10 % 350,0 мянган төгрөг, ажил олгогчийн төлөх НДШ 11% 385,0 мянган төгрөг, нийт 735,0 мянган төгрөгийг дутуу тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн” гэсэн заалтыг зөрчсөн байна.	Нийгмийн даатгалын тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах. Тайлант хугацаанд дутуу тайлагнасан НДШ-ийг нөхөн тооцож, нийгмийн даатгалд тайлагнан байгууллагыг эрсдэлээс хамгаалах.
Эрсдэл	Үйлчлүүлэгчийн хариу
Нийгмийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтын дагуу нөхөн төлбөр, алданги, торгууль төлөх эрсдэлтэй.	Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ

Асуудал 1: Эздийн өмч	Тэргүүлэх ач холбогдол №2
------------------------------	----------------------------------

Бодит байдал	Зөвлөмж
Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн хөрөнгийн хэмжээ 1,029.1 сая төгрөгөөр бүртгэгдсэн боловч, Санхүүгийн тайлангаар Засгийн газрын оруулсан хөрөнгө 1,258.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй, ба 229.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна.	Улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн бүртгүүлэх.
Эрсдэл	Үйлчлүүлэгчийн хариу
Эздийн өмч буруу бүртгэгдэж, мэдээлэл хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангаж чадахгүйд хүргэх.	Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

Асуудал 2: Авлага, өглөгийн талаар**Тэргүүлэх ач
холбогдол №2**

Бодит байдал	Зөвлөмж
НДШ-ийн тайлангаар 3,2 мянган төгрөг, ХХОАТ-ын тайлагнаар 458,9 мянган төгрөгийн илүү төлөлтийг бүртгэлд тусгаагүй, 2016 оны жилийн эцсийн байдлаар Адмон принт ХХК-д номны үнэ 1005000 төгрөгийн өглөгтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.	Төсвийн тухай хууль, УСНББОУС болон түүнд нийцүүлэн гаргасан заавар, журмыг тууштай мөрдөж цаашид өр, авлага үүсгэхгүй ажиллах.
Эрсдэл	Үйлчлүүлэгчийн хариу
Тайлант хугацааны үр дүн болон авлага, өглөг илүү/дутуу илэрхийлэгдэх, Төсвийн тухай хууль, стандарт, заавар, журам зөрчих.	Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

**“Чойжин ламын сүм музей” төсвийн байгууллагын
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2015 оны 12 дугаар сарын 31	Аудитлагдсан 2016 он 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Бараа материал	29 356 469,00	44 474 590,00
Хангамжийн материал	29 356 469,00	44 474 590,00
Бичиг хэргийн материал	1 098 750,00	8 408 421,00
Аж ахуйн материал	14 385 308,00	14 349 658,00
Сэлбэг хэрэгсэл	275 000,00	275 000,00
Бусад хангамжийн материал	13 597 411,00	21 441 511,00
Эргэлтийн хөрөнгийн дүн	29 356 469,00	44 474 590,00
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө		
Биет хөрөнгө	4 095 002 086,68	4 053 506 688,76
Барилга байгууламж	47 281 000,00	47 281 000,00
Хуримтлагдсан элэгдэл	(17 151 994,12)	(18 730 010,92)
Машин, тоног төхөөрөмж	191 692 914,48	195 752 914,48
Хуримтлагдсан элэгдэл	(106 277 244,24)	(146 293 225,32)
Тавилга эд хогшил	67 491 779,00	67 491 779,00
Хуримтлагдсан элэгдэл	(37 611 247,44)	(41 572 647,48)
Түүх соёлын дурсгалт зүйлс	3 947 692 959,00	3 947 692 959,00
Номын фонд	1 883 920,00	1 883 920,00
Биет бус хөрөнгө	247 500,00	-
Программ хангамж	990 000,00	990 000,00
Хасагдуулга	(742 500,00)	(990 000,00)
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4 095 249 586,68	4 053 506 688,76
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4 124 606 055,68	4 097 981 278,76
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		1 005 000,00
Бусад өглөг	-	1 005 000,00
Өр төлбөрийн нийт дүн	-	1 005 000,00
ӨМЧ		
Засгийн газрын оруулсан капитал	1 258 814 021,00	1 258 814 021,00
Өмнөх үеийн үр дүн	329 591 012,68	329 591 012,68
Тайлант үеийн үр дүн	-	(27 629 776,92)
Дахин үнэлгээний зөрүү	2 536 201 022,00	2 536 201 022,00
Эздийн өмчийн дүн	4 124 606 055,68	4 096 976 278,76

ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН

4 124 606 055,68

4 097 981 278,76

**“Чойжин ламын сүм музей” Төсвийн байгууллагын
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31

ҮЗҮҮЛЭЛТ	15.12.31	16.12.31
Үйл ажиллагааны орлого		
Тусламж санхүүжилтийн орлого	172 631 800,00	183 347 900,00
Урсгал санхүүжилт	172 631 800,00	183 347 900,00
Улсын төсвөөс	172 631 800,00	183 347 900,00
Бараа үйлчилгээний орлого	129 838 029,00	74 823 400,00
Үндсэн үйл ажиллагааны орлого	73 597 000,00	66 474 000,00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1 600 000,00	759 400,00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	54 641 029,00	7 590 000,00
Үйл ажиллагааны орлогын дүн	302 469 829,00	258 171 300,00
Үйл ажиллагааны зардал		
Бараа үйлчилгээний зардал	277 301 286,47	276 783 463,92
Ажилчидтай холбогдсон зардал	154 321 279,00	153 257 611,00
Цалин хөлс нэмэгдэл урамшил	139 298 010,00	137 958 367,00
Нийгмийн хамгаалалын шимтгэл	15 023 269,00	15 299 244,00
Тогтмол зардал	11 780 996,00	22 893 476,00
Гэрэл цахилгааны зардал	11 193 520,00	22 575 000,00
Цэвэр, бохир усны зардал	587 476,00	318 476,00
Хангамж, бараа материалын зардал	3 171 663,00	5 543 150,00
Бичиг хэргийн зардал	455 700,00	1 227 288,00
Тээвэр, шатахууны зардал	174 000,00	133 100,00
Шуудан холбоо интернэтийн зардал	595 913,00	710 712,00
Хог хаягдал устгах, цэвэрлэх	967 500,00	1 622 700,00
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	978 550,00	1 849 350,00
Эд хогшил урсгал засварын зардал	4 138 500,00	2 734 500,00
Багаж хэрэгсэл	2 686 000,00	77 000,00
Урсгал зардал	1 452 500,00	2 657 500,00
Томилолт зочны зардал	524 000,00	1 519 100,00
Дотоод томилолтын зардал	524 000,00	1 519 100,00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	51 386 100,00	45 032 729,00
Бараа үйлчилгээний бусад зардал	51 978 748,47	45 802 897,92
Бусад зардал	6 225 539,00	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	45 753 209,47	45 802 897,92
Урсгал шилжүүлэг	7 035 341,00	9 017 613,00
Үйл ажиллагааны зардлын дүн	284 336 627,47	285 801 076,92

Үйл ажиллагааны нийт үр дүн

18 133 201,53

(27 629 776,92)

**“ Чойжин ламын сүм музей” Төсвийн байгууллагын
АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015 оны 1 -р сарын 1-ний үлдэгдэл	1 258 814 021,00	2 536 201 022,00	311 457 811,15	4 106 472 854,15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 258 814 021,00	2 536 201 022,00	311 457 811,15	4 106 475 854,15
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз гарз				
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-	-	18 133 201,53	18 133 201,53
2015 оны 12 -р сарын 31-нээрх үлдэгдэл	1 258 814 021,00	2 536 201 022,00	329 591 012,68	4 124 609 055,68
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 258 814 021,00	2 536 201 022,00	329 591 012,68	4 124 606 055,68
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз гарз				
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал			(27 629 776,92)	(27 629 776,92)
Өмчид гарсан өөрчлөлт				-
Зарласан ногдол ашиг				-
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 258 814 021,00	2 536 201 022,00	301 961 235,76	4 096 976 278,76

**“Чойжин ламын сүм музей” Төсвийн байгууллагын
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Тусламж санхүүжилтийн орлого	175 963 333,00	184 308 364,00
Улсын төсөвөөс	172 631 800,00	183 347 900,00
Нийгмийн даатгалын сангаас	3 331 533,00	960 464,00
Бараа үйлчилгээний орлого	75 197 000,00	67 402 000,00
Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого	75 197 000,00	67 402 000,00
Үндсэн үйл ажиллагааны орлого	73 597 000,00	66 474 000,00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1 600 000,00	928 000,00
Бусад орлого	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	251 160 333,00	251 710 364,00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	229 340 459,00	238 632 751,00
Ажилчидтай холбогдсон зардал	154 316 700,00	154 218 075,00
Цалин хөлс нэмэгдэл урамшил	139 024 100,00	138 955 564,00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15 292 600,00	15 262 511,00
Бараа үйлчилгээний урсгал зардал	75 023 759,00	84 414 676,00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11 780 996,00	22 893 476,00
Гэрэл цахилгааны зардал	11 193 520,00	22 575 000,00
Цэвэр, бохир усны зардал	587 476,00	318 476,00
Хангамж, бараа материалын зардал	3 465 213,00	4 948 200,00
Бичиг хэргийн зардал	519 500,00	1 349 488,00
Тээвэр, шатахууны зардал	174 000,00	133 100,00
Шуудан холбоо интернэтийн зардал	595 913,00	710 712,00
Хог хаягдал устгах, цэвэрлэх	967 500,00	1 622 700,00
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	1 208 300,00	1 132 200,00
Нормативт зардал	322 000,00	644 100,00
Эд хогшил урсгал засварын зардал	5 192 500,00	3 203 000,00

Томилолт зочны зардал	524 000,00	1 519 100,00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	53 739 050,00	51 038 200,00
Бараа үйлчилгээний бусад зардал		168 600,00
Урсгал шилжүүлэг	10 366 874,00	9 017 613,00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	239 707 333,00	247 650 364,00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	11 453 000,00	4 060 000,00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	11 453 000,00	4 060 000,00
Биет бус хөрөнгө худалдан авсан	11 453 000,00	-
Биет хөрөнгө худалдан авсан	-	4 060 000,00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	11 453 000,00	4 060 000,00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(11 453 000,00)	(4 060 000,00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

**“Чойжин ламын сүм музей” Төсвийн байгууллагын
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**
2016 оны 12 дугаар сарын 31

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨСӨВ	ГҮЙЦЭТГЭЛ	ДҮН	ХУВЬ
НИЙТ ЗАРДАЛ	242 983 900,00	241 563 687,00	1 420 213,00	99,4
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	242 983 900,00	241 563 687,00	1 420 213,00	99,4
Цалин хөлс нэмэгдэл урамшил	139 024 100,00	137 995 100,00	1 029 000,00	99,3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	15 292 600,00	15 262 511,00	30 089,00	99,8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23 004 500,00	22 893 476,00	111 024,00	98,4
Хангамж бараа материалын зардал	4 687 200,00	4 948 200,00	-	105,6
Бичиг хэрэг	925 500,00	1 349 488,00	- 423 988,00	203,1
Тээвэр шааихуун	133 100,00	133 100,00	-	100,0
Шуудан холбоо	741 200,00	710 712,00	30 488,00	95,9
Хог хаягдал устгах цэвэрлэх	1 622 700,00	1 622 700,00	-	100,0
Бага үнэтэй түргэн элэгдэх, аж ахуй эд зүйлс	1 525 700,00	1 132 200,00	393 500,00	74,2
Нормативт зардал	644 100,00	644 100,00	-	100,0
Эд хогшил худалдан авах	7 263 100,00	7 263 000,00	100,00	100,0
Багаж, техник, хэрэгсэл	4 313 000,00	4 313 000,00	-	100,0
Урсгал засвар	2 950 100,00	2 950 000,00	100,00	100,0
Томилолт, зочны зардал	1 519 100,00	1 519 100,00	-	100,0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,үйлчилгээний төлбөр	51 288 200,00	51 038 200,00	250 000,00	99,5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,үйлчилгээний төлбөр	43 925 200,00	43 925 200,00	-	100,0
Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох	1 800 000,00	1 800 000,00	-	100,0
Мэдээллийн технологийн зардал	1 100 000,00	1 100 000,00	-	100,0
Газрын төлбөр	1 720 400,00	1 720 400,00	-	100,0
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250 000,00	-	250 000,00	0,0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2 492 600,00	2 492 600,00	-	100,0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	-	0,0
Бусад урсгал шилжүүлэг	-	-	-	0,0
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	-	-	0,0
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	242 983 900,00	241 563 687,00	1 420 213,00	99,4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	242 983 900,00	241 563 687,00	1 420 213,00	99,4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58 658 500,00	66 474 000,00	- 7 815 500,00	113,3

Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	977 500,00	759 400,00	218 100,00	77,7
Төсвөөс санхүүжих	183 347 900,00	174 330 287,00	9 017 613,00	95,1
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	0,0
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	0,0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	1,0
АЖИЛЛАГСАД БҮГД	20,00	20,00	-	100,0
Удирдах ажилтан	1,00	1,00	-	100,0
Гүйцэтгэх ажилтан	7,00	7,00	-	100,0
Үйлчлэх ажилтан	12,00	12,00	-	100,0